



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 03 дугаар сарын 11 өдөр

Дугаар 23

Хэрлэн сум

ХХIII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 23 дугаар хуралдаан 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 18:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 82,0 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Улсын Онцгой комиссын 2021 оны 07 дугаар хуралдааны шийдвэрийг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

2.Коронавируст халдвар /COVID-19/ тархах эрсдэлийн салбар дундын үнэлгээг танилцуулах,

Эрүүл мэндийн газар

3.Хот хоорондын зорчигч тээврийн хэрэгсэлд хязгаарлалт тогтоох эсэх талаар хэлэлцэх,

Цагдаагийн газар

4.Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн санал, хүсэлтийг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:


Нэг.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын
гишүүн Б.Ганганцэцэг нарт:

1.1.Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрсдэлийн үнэлгээ хийх талаар сумдын Онцгой комисст сургалт зохион байгуулах,

Сумын Засаг дарга нарт:

1.2.Мэргэжлийн байгууллагуудын зөвлөмжийн дагуу коронавируст халдвар /COVID-19/-ын үеийн сумын эрсдэлийн үнэлгээг хийж дүгнэлтийг аймгийн Онцгой комисст хүргүүлэхийг,


/ Ч.Ганбат
/ Д.Баттулга

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.1.Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улаанбаатар хот болон голомттой бүс нутгаас хүндэтгэн үзэх шалтгаан /албан томилолт, эрүүл мэнд, ар гэрийн гачигдал, ачаа тээвэр/-аас бусад тохиолдолд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 06:00 цагаас эхлэн тодорхойгүй хугацаагаар хязгаарлахыг, хот хоорондын зорчих хөдөлгөөнийг Чойбалсан-Улаанбаатар чиглэлд Лхагва гарагт 1 автобус, Улаанбаатар-Чойбалсан чиглэлд Бямба гарагт 1 автобус зорчуулахыг зөвшөөрсөн тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргахыг,

Гурав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

3.1.Эрүүл мэндийн газраас аймгийн Онцгой комисст ирүүлсэн нэг удаагийн оношлуур 1000 ширхэгийг 10,000,000 төгрөгөөр худалдан авах хүсэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.2.Эрүүл мэндийн газраас аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Нэг удаагийн оношлуур худалдан авах хөрөнгө шийдвэрлүүлэх тухай” хүсэлтийн дагуу нэг удаагийн оношлуур худалдан авахад шаардагдах 4,164,500 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Эрүүл мэндийн газарт олгохыг зөвшөөрөв,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

3.3.Төрийн албаны шалгалтад хамрагдахаар бүртгүүлсэн Улаанбаатар хотоос 7 хоногийн өмнө ирсэн Дорнод аймгийн харьяалалтай 9 иргэдийг тусгаарлан бэлтгэсэн өрөөнд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн төрийн албаны шалгалтад хамруулахыг зөвшөөрөв,

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН
ОРЛОГЧ ДАРГА Ч.ГАНБАТ

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА

